



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 3Ү

Улаанбаатар хот

Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ,
нөхцөл тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2, 55.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7.3.8 дахь заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хараат бус үнэлгээний байгууллага болох "Гэрэгэ эстимэйт" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн олон нийтэд санал болгох 119,157,603 ширхэг энгийн хувьцааны нэг бүрийн үнийг тогтоосон үнийн аргаар 100 (нэг зуу) төгрөгөөр тогтоосугай.

2. Компанийн нийтэд санал болгон нэмж гаргах 119,157,603 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргах нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хувьцаагаа бүртгүүлэн арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.


4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хорооны дарга /А.Анар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1522010091


 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
 Төлөөлөн удирдах зөвлөлийн
 2022 оны 1 сарын 27 өдрийн
 37 дугаар тэтгэмжийн хэвлэлт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
 ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
 ХУВЬЦААГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НӨХЦӨЛ,
 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**

№	Үзүүлэлт	Нөхцөл
1. Үнэт цаас нэмж гаргах нөхцөл		
	Үнэт цаас гаргагч	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
	Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
	Үнэт цаасны үсгэн код	MSE
	Нэмж гаргах энгийн хувьцааны тоо	119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав) ширхэг
	Энгийн хувьцааны нэрлэсэн үнэ	100 (нэг зуу) төгрөг
	Нэмж гаргаж буй буюу олон нийтийн эзэмших хувь	34%
	Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг
	Нэгж хувьцааг олон нийтэд санал болгох үнэ	100 (нэг зуу) төгрөг
	Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
2. Үнэт цаас нийтэд санал болгох нөхцөл		
	Анхдагч зах зээлийн арилжааны арга	Тогтоосон үнийн арга
	Хөрөнгө оруулах доод хэмжээ	Байхгүй
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	11,915,760,300 (арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу) төгрөг
	Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувь, хэмжээ	<p>Нэмж гаргах хувьцааны 90 хүртэлх хувь буюу 107,241,842 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох;</p> <p>Нэг стратегийн хөрөнгө оруулагчид нийт эзэмшлийн 5 хүртэл хувь буюу хамгийн ихдээ 17,523,176 ширхэг энгийн хувьцааг санал болгох;</p> <p>Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаа буюу 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх.</p>

Үнэт цаасыг амжилттай татан төвлөрүүлсэн гэж үзэх хувь (анхдагч зах зээлийг арилжаа хаагдсан өдөр)	100%
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	
Техник, технологийн шинэчлэл.Үүнд:	
- Арилжааны системийн сайжруулалт	63.7%
- Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
- Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
- Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%

-----oOo-----